

ДОРНОД АЙМАГ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 11

Хэрлэн сум

Дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.16, 15.17, 15.18 дахь заалт, Дорнод аймаг дахь Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан дүрмийн 3 дугаар зүйлийн 3.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.9 дэх заалтыг хуульд нийцүүлэн “ээлжит болон ээлжит бус хуралдааны алинд ч хурал зохион байгуулах хүчинтэй ирц нь дийлэнх олонх буюу 66.6 хувиас доошгүй байна” гэж өөрчилсүгэй.

2. Тус дүрмийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь заалтыг “Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлтэй танилцаж болох бөгөөд тэмдэглэлд зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна” гэж өөрчлөх, мөн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтыг “хурлын тэмдэглэлийг зөвлөлийн гишүүдэд танилцуулж, баталгаажуулж, архив үүсгэх” гэж өөрчилсүгэй.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь заалтын “мөн 4.12-т заасныг мөрдлөг болгох” гэснийг хассугай.

4. Тогтоолыг гарсан өдрөөс эхэлж мөрдөх бөгөөд тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг гишүүд, нарийн бичгийн дарга /М.Цэрэндаваа/-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХБААТАР